

ARD САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ

2014 ЖИЛИЙН ТАЙЛАН



Эрхэм Зорилго

Хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгахын тулд ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэртэй барих бодлогыг чиглэл болгон ажиллана.

Хүчтэй. Хамтдаа

Алсын Хараа

Бид Монгол Улсын хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани байхыг зорьж ажиллах бөгөөд хөрөнгө оруулагчдын санхүүгийн өгөөжийг дээдлэх бодлогыг баримтална.

АГУУЛГА

1) Удирдлагын илгээлт	4
2) Эдийн засгийн тойм	8
3) Хөрөнгө оруулалтын зах зээл	12
4) Ард Санхүүгийн Нэгдэл	16
4.1. Танилцуулга	18
4.2. Бүтэц	20
4.3. Санхүүгийн тайлан	22
4.4. Үйл ажиллагаа	24
4.5. Үнэлгээ	26
4.6. Хувьцааны арилжаа	27
4.7. Ойрын ирээдүйн стратеги	28
5) Хараат болон хөрөнгө оруулалттай компаниудын тайлан	30
5.1. Ард Даатгал	32
5.2. Ард Кредит	33
5.3. Ард Актив	34
5.4. Ард Секюритиз	35
5.5. ТТДС	36
5.6. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл	37
5.7. ТэнГэр Системс	38
5.8. Номын Хишиг	39
5.9. Уайлд Дижитал Эйжэнси	40

1.

ИЛГЭЭЛТ





УДИРДЛАГЫН ИЛГЭЭЛТ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч таны энэ өдрийн амар амгаланг эрэн мэхийн ёсолъё!

2014 он Ард Холдингсын хувьд шинэ нэрэн дор, шинэ баг бүрэлдэхүүнээр том зорилго дэвшүүлэн ажилласан анхны жил болж өндөрлөлөө. Бид өнгөрөгч онд лого, бэлгэдлээ гарган баталж, “Хүчтэй, Хамтдаа” уриан дор цоо шинэ үндэсний санхүүгийн нэгдлийн суурийг тавихаар шамдан ажилласан болно. Монголын эдийн засгийн нөхцөл байдал амаргүй байсан боловч таны хувь нийлүүлсэн компани үйл ажиллагаагаа өргөжүүлэн бэхжүүлж, санхүүгийн хувьд тогтвортой үзүүлэлт гаргасан он жил боллоо. Бид үйл ажиллагааны бүтцийн хувьд хамгийн цомхон бөгөөд чадварлаг бүрэлдэхүүнээр ажиллаж, санхүүгийн чанд сахилга батыг мөрдлөг болгон эдийн засгийн энэ хүндрэлтэй үеийг амжилттай даван туулж байна.

Манай компанийн үнэлгээ 29.4 тэрбум төгрөгөөс 34.0 тэрбум болон өсөж, санхүүгийн хувьд 4.5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Хувьцаа эзэмшигч таны нэгж хувьцааны үнэлгээ оны сүүлчээр 2,024.3 төгрөг байна. Манай хувьцаа эзэмшигчдийн тоо 331 хүртэл буурч, хувь эзэмшлийн төвлөрөл явагдсаар байна. Шинээр хэд хэдэн хөрөнгө оруулагчид манай компанид хувьцаа эзэмшигчээр орж ирсэн бөгөөд 2014 онд нийт 4.6 орчим тэрбум төгрөгийн хувьцаатай холбоотой хэлцэл хийгдсэн байна. Голландын ВенчурсУан БиВи Ард Даатгал компанийн 22.31 хувьтай тэнцэх хувьцаагаа манай толгой компанийн 1,304,043 ширхэг хувьцаагаар сольж орж ирлээ. 2014 оны эцсийн байдлаар Ард Санхүүгийн Нэгдэлийн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй та 20 дугаар хуудаснаас танилцана уу.

Нэгдэл компаниудын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитыг Английн BDO Аудитын Монгол дахь салбар хийж гүйцэтгэснээр EIT компани үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш анх удаагаа олон улсын аудитын компаниар санхүүгийн тайлангаа баталгаажуулж, 2014 оны санхүүгийн тайланд хийх аудитыг мөн BDO Аудит компаниар хийлгэлээ.

Хуучин туршлага, шинэ эрч хүчийг хослуулсан хүчирхэг нэгдлийн гарааны жил үйл ажиллагаа явуулж буй орчин таагүй, эдийн засгийн болон санхүүгийн хямрал нүүрлэсэн хэдий ч бидний хөрөнгө оруулалттай компаниуд бүхий л талаараа амжилт бүтээл дүүрэн ажиллалаа.

Монголын Тэтгэврийн Нэрийн Данс ХХК-ийг татан буулгаж, 10 шахуу жил хуримтлуулсан хувийн тэтгэврийн нэрийн дансны үйл ажиллагааг амжилттай өөрчлөн зохион байгуулж, Ард Актив хэмээх хадгаламж зээлийн хоршоонд урт хугацаат хадгаламжийн үйлчилгээг нэвтрүүлэн гурвалсан гэрээний үндсэн дээр ажиллаж эхэллээ.

Монгол Улсын ууган хувийн даатгалын компани үүсгэн байгуулагдсан 20 жилийн ойн баяраа тэмдэглэсэн Ард Даатгал компанийн хувьцаанаас бид 22.31 хувийг нэмж аван 55.31 хувийг эзэмших боллоо. Нийт салбарын хувьд орлого нь тасалдаж, нөхөн төлбөр их гарсан бол Даатгалын хамт олон 10 гаруй тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн борлуулалт хийж, 500 гаруй сая төгрөгийн ашигтай ажиллаж чадлаа. Ард Даатгалын хувьд засаглалын тогтолцоогоо сайжруулж, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн он гарахын өмнөхөн хотын төвд шинээр ажлын байр худалдан авах чухал шийдвэрийг гаргалаа. Ингэснээр бид нэг талаас өөрийн нөөц хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, түрээсийн зардлаа үлэмж хэмжээгээр хэмнэх, бусад орлогоо өсгөх боломж нээгдэж байна.

Оны туршид уйгагүй ажиллаж, судалгаа шинжилгээ хийсний үр дүнд Монголын анхны хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх шийдвэрийг манай хувь нийлүүлэгчид гарган тусгай зөвшөөрөл авах, үйл ажиллагааг нь эхлүүлэх ажлыг Ард Секюритиз компани (хуучнаар Монет Капитал) гүйцэтгэж байна. Мөн энэ зорилгоо гүйцэлдүүлэхээр Ард Капитал Менежмент нэртэй сангийн удирдлагын

компанийг 100 сая төгрөгийн дүрмийн сантайгаар үүсгэн байгуулахыг манай хувьцаа эзэмшигчид дэмжлээ.

Ард Кредит нь манай багцын бүх талаар хамгийн сайн үзүүлэлттэй компани болон цойлж гарч ирлээ – тэрбээр шинээр бондын хөрөнгийг амжилттай босгож, Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан болон арилжааны банкнаас зээлийн санхүүжилт татан авч, итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлэн нийт 300 гаруй сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Энэ онд Кредит маань хувь нийлүүлэгчиддээ анх удаа ашгийн 30 гаруй хувиа ногдол ашгаар хуваарилах шийдвэрийг гаргалаа.

2014 онд Техник Технологийн Дээд Сургуулийн 30 жилийн ойг тэмдэглэж өнгөрүүлсэн бөгөөд тус сургуулийн дэргэд шинээр Монгол Коосэн Технологийн ахлах сургууль, Технологи Нэвтрүүлэх Төвийн үндэс суурийг тавьж, цаашдын далайцтай ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

Өнгөрсөн жил Уайлд Дижитал Эйженси компанийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсэн анхны жил болсон бол манай бүрэлдэхүүнд үйл ажиллагаа явуулдаг бас нэгэн технологийн компани болох ТэнГэр Системсийн шинээр боловсруулсан Тэрбиум банкны удирдлага бүртгэлийн систем нь Монголын банк санхүүгийн зах зээлд богино хугацаанд танигдаж, өөрийн байр суурийг олж авна гэдэгт бид итгэл төгс байна.

ТэнГэрийн хувь нийлүүлэгчидтэй хийсэн тохиролцооны даруу Equity Investment Trust Capital Management компанийг татан буулгаж, ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцааг MCS болон Mongolia Opportunity Fund-ын хамт шууд эзэмшиж эхэллээ. Оны сүүлчээр ТэнГэрийн хувьцааг Канадын Үндэсний Банкинд зарах саналууд MCS болон Mercy Corps-оос ирсэн бөгөөд бид цаашид хэрхэх талаар яг энэ мөчид судалж, тодорхой саналуудыг ТУЗ болон хувь нийлүүлэгчдээрээ хэлэлцүүлэх ажлыг хийж байна.

ТУЗ-ийн нийт гишүүд уйгагүй ажиллаж, идэвх чармайлт гарган асар богино хугацаанд сайн засаглалын тэргүүний зарчмуудыг үйл

ажиллагаандаа нэвтрүүлж чадлаа. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын заагийг гарган өгч, хороодын ажиллагааг идэвхжүүлсэн бөгөөд Жанчивын Оюунгэрэл ТУЗ-ийг удирдан ажиллаж эхэллээ. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Чулууны Ганхуяг хариуцан ажиллаж байна. МАК-ийн төлөөлөл солигдож Нямтайширын Цэлмүүн эргэн ТУЗ-ийн эгнээнд нэгдлээ. Харин Ард Даатгалын хувийг нэмж авах хэлцлийн үр дүнд ВенчурсУан БиВи манай ТУЗ-д төлөөлөлтэй болох тохироо хийгдэж ноён Энтони Хоброу анхны гадаад гишүүнээр орж ирэв. Манай өнөөгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тайлангийн 20-21 дүгээр хуудаснаас харна уу.

2015 онд компани Монголын Хөрөнгийн Бирж дээр гарч, хувьцаагаа олон нийтэд санал болгож, чөлөөтэй арилжаалах зорилтыг дэвшүүлэн ажиллах түүхэн шийдвэрийг ТУЗ болон хувь нийлүүлэгчид санал нэгтэй гаргасан бөгөөд гүйцэтгэх удирдлага үүнийг ажил хэрэг болгохын төлөө бүхий л хүч, нөөц бололцоог дайчлан ажиллаж эхлээд байна. Он гарсаар бид Жинст Увс хувьцаат компанийн 84.6 хувийг блок арилжаагаар худалдан авч, нийлэх үйл явцыг хийхэд бэлэн боллоо. Бидний хувьд эхний ээлжинд хаалттай хувьцаат компани болон бүртгүүлж, эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, зах зээл сэргэх үед МХБ-д бүртгүүлэн олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох бодлогыг баримталж ажиллаж байна.

2014 он дуусахын өмнөхөн бид нэгэн шийдвэрийг гаргасан нь түүхэн гараагаа анх авч байсан хуучин Өнгөт Хэвлэлийн байрандаа өөрийн оффисыг нүүлгэн авч ирсэн явдал байлаа. Энэ нь 2015 онд бидний төлөвлөж байгаа том ажлын нэг чухал хэсэг гэж бид үзэж байна.

Ард Санхүүгийн Нэгдэлийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх удирдлагын нэрийн өмнөөс 2015 онд танд аз хийморьтой, олз омог ихтэй байхын ерөөлийг дэвшүүлье!

Хүчтэй, Хамтдаа!

Жанчивын Оюунгэрэл
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

Чулууны Ганхуяг
Гүйцэтгэх Захирал

2.

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ





ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2014 оныг ерөнхийд нь эдийн засгийн тогтворгүй байдал болон инфляцийн түвшин өндөр байсантай холбоотойгоор удаашралын жил гэж судлаачид тодорхойлоод байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2013 онд 11.7 хувь байсан бол 2014 онд 7.8 хувь болж буурсан үзүүлэлттэй байлаа. Гурван жилийн өмнөх дэлхийд тэргүүлж байсан 17.5 хувьтай харьцуулбал энэхүү үзүүлэлт нь тун чамлалттай юм. Худалдааны тэнцэл 538 сая долларын илүүдэлтэй гарсан нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнтэй холбоотой.




Экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн баяжмал, боловсруулаагүй газрын тос болон алтны экспорт нэмэгдсэн нь дээрх үзүүлэлтэд нөлөөлсөн байна. Малын тоо толгой 52 саяд хүрч, эдийн засгийн уламжлалт салбар болох хөдөө аж ахуйн салбар 14.4 хувиар өссөн, экспортын голлох бүтээгдэхүүнүүдээс зэсийн баяжмал, газрын тосны олборлолт, экспортын хэмжээ огцом өсөж, 2014 онд 1.4 сая тонн зэсийн баяжмал, 6.9 сая тонн газрын тос экспортолсон нь уул уурхайн салбарт өндөр өсөлт гарахад голлон нөлөөлжээ. Эдийн засгийн өсөлтийн хурдац саарч, бизнесийн идэвхжил суларч байгаагаас 2014 онд худалдааны салбар 6.9 хувийн уналттай гарлаа.

2014 оны 11 дүгээр сард Норовын Алтанхуягийн Засгийн Газар огцорч, шинэ Ерөнхий Сайдаар Чимэдийн Сайханбилэг томилогдлоо. Шинэ сайд өмнөх Ерөнхий Сайдаас гадаадын хөрөнгө оруулалт хамгийн доод цэгтээ хүрсэн, ашигт малтмалын үнэ болон эрэлт буурч, экспортын орлого тасалдсан, зогсонги байдалд орсон эдийн засгийг хүлээж авсан.

Улсын хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляци 2012 онд 14 хувь байсан бол 2013 онд бага зэрэг буурч 12.5 хувьд хүрсэн бол 2014 оны эцсээр инфляци 11 хувьтай гарлаа. Харин Улаанбаатар хотын инфляцийн түвшин 10.7 хувьтай байв. 2014 оны 1, 4, 6 дугаар саруудад үнийн өсөлт хамгийн өндөр байсан бол оны төгсгөлд инфляцийн түвшин тогтворжих хандлагатай байв.


Монголын Хөрөнгийн Бирж дээр 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 255 удаагийн арилжаагаар 137 компанийн 51.7 сая ширхэг хувьцааг 24.2 тэрбум төгрөгөөр, Засгийн Газрын үнэт цаасны 9 удаагийн арилжаагаар 375.5 мянган ширхэг үнэт цаасыг 36.1 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 60.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 40.2 хувь нь хувьцааны арилжааны дүн, 59.8 хувь нь Засгийн газрын үнэт цаасны арилжааны дүн тус тус эзэлж байна. Зах зээлийн үнэлгээ 2014 оны эцсээр 1.4 их наяд төгрөг байгаа нь мөн өмнөх оныхоос 13.6 хувиар буурсан үзүүлэлт юм.

ДНБ-ийн өсөлт | %, салбараар |




- Санхүүгийн болон даатгал
- Бөөний болон жижиглэн худалдаа
- Барилга
- Боловсруулах үйлдвэр
- Уул уурхай
- Хөдөө аж ахуй
- Бусад

Гадаад худалдаа | сая доллар |




- Экспорт
- Импорт
- Тэнцэл

Гадаадын шууд хөрөнгө оруулалт | тэрбум төгрөг |




Үнэт цаасны арилжаа | тэрбум төгрөг |




- Хувьцаа
- Засгийн газрын бонд
- Компанийн бонд

Валютын ханш | Доллар |



Инфляцийн түвшин | хувь |



3.


ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ЗАХ ЗЭЭЛ







ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАХ ЗЭЭЛ



Эх сурвалж: Mongolian Economy сэтгүүл, 2015 оны 3 дугаар сар №06 (085)
 Монгол Банк



2012 оны дунд үед 4.8 тэрбум долларт хүрч байсан гадаадын хөрөнгө оруулалт, 2013 онд 2.1 тэрбум доллар, 2014 онд 644 сая долларт хүрээд байна. Үүнд улс төр, хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, мега төслөөс хараат байдал, түүхий эдийн үнийн уналт зэрэг суурь хүчин зүйлс шууд нөлөөлж байна.

Оны эхний есөн сарын байдлаар Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт (ГШХО) 647.5 сая доллар байгаа нь 2012 оны үзүүлэлтийн тавны нэгд ч хүрэхгүй байна. Нэгдүгээр сараас тавдугаар сар хүртэлх хөрөнгө оруулалт өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулахад 64 хувиар буурсан байна.

ГШХО-ыг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын хуулийг хөнгөрүүлэх, шинэ болон хуучин цуцлагдсан эсвэл хойшлуулагдсан тендерийг дахин нээх оролдлого хэрэгжих гэж байна. Хятад болон ОХУ-тай 2014 оны сүүлээр байгуулсан хэлэлцээр нь гадаадын хөрөнгө оруулалтыг хурдасгах нөхцөл байдлыг бүрдүүлж өгч байгаа нь цаашид худалдааг нэмэгдүүлэх, тээвэр, дэд бүтэц, аж үйлдвэрийн салбарт ахиц гаргах боломжтой болох юм. Орос болон Хятад улстай хийх худалдаа 10 тэрбум долларт хүрэх болно гэсэн эхний зорилт тавигдаад байна. Энэ нь Монголын төмөр замын сүлжээнд чамгүй том түлхэц өгч, нэмэлт хөрөнгө оруулалт болохуйц дэвшил төдийгүй Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн чадавхийг сайжруулах юм.

2014 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хурлаас “Эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталж, мөн Эрдэс баялгийн тухай болон Газрын тосны тухай хуульд удаан хүлээсэн нэмэлт өөрчлөлтийг оруулж баталсан ч ГХХО-ын таатай орчин бүрдүүлэх талаар Монголын талаас авч буй арга хэмжээ нь бодит байдлаас илүү хүсэл эрмэлзлэлийн чанартай байна гэж хөрөнгө оруулагчид дүгнэж байна. Уул уурхайн томоохон төслүүдийг урагшлуулж, Рио Тинтотой эв зүйгээ олж, Оюу Толгой төслийн хөрөнгө оруулалтын талаар нэгдсэн байр сууринд хүрч, Таван Толгой төслийг мөн эдийн засгийн эргэлтэд яаралтай оруулах нь эргэлзээтэй байгаа гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж, хөрөнгө оруулалтын урсгалыг татах томоохон хүчин зүйл болох юм.



4.

АРД САНХҮҮГИЙН
НЭГДЭЛ



Stronger Together.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Ард Санхүүгийн Нэгдэл буюу Ард Холдингс нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй манлай компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь дээшлүүлэх замаар өөрийн хувь нийлүүлэгчдийн өгөөжийг өсгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм. Манай бүрэлдэхүүнд Ард Даатгал, Ард Кредит, Ард Секюритиз (Монет Капитал), Ард Актив, Ард Капитал Менежмент болон Хөрөнгө Оруулалтын Итгэлцлийн Сан (ЕИТ) багтаж байна. Манай хөрөнгө оруулалтын сангаас Техник Технологийн Дээд Сургууль, Номын Хишиг, Уайлд Дижитал Эйжэнси, ТэнГэр Системс зэрэг компанид хөрөнгө оруулалт хийн удирдлагад нь идэвхтэй оролцож, харилцан ашигтай хамтын ажиллагааны үндэс суурийг бий болгож ажиллаж байна.


Анх 2000 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар болон АНУ-ын Мэрси Корпс төрийн бус байгууллагаас ХасБанкны ажиллагсад болон байгууллага, түүний хувь нийлүүлэгчдийн урт хугацааны ашиг сонирхлыг нийцүүлэх, бизнес санхүүгийн салбарт оруулж буй хувь нэмрийг нь үнэлэн ХасБанкны нийт ажиллагсдад 600 сая төгрөгийг ажиллагсдын хувьцаа эзэмшүүлэх санд хандивлах шийдвэрийг гаргасан юм.

Улмаар ХасБанкны ажиллагсад тус сангаас олгогдсон хувьцааны үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх зорилго дор нэгдэн бүгд өөрсдийн хувьцаагаа ХасБанкны толгой компани болох ХАС-GE ХХК-ийн хувьцаагаар сольж хөрөнгө оруулалт хийсэн болно.

ХАС-GE нь хөгжлийнхөө явцад ТэнГэр Санхүүгийн Нэгдэл болж өөрчлөгдсөн бөгөөд банк, даатгал, лизингийн үйлчилгээ үзүүлдэг томоохон санхүүгийн компаниудын нэгдэл юм.

Манай компани нь 2005 оны 9 дүгээр сард ХасБанкны анхдагч 10 ажиллагсдын санаачилгаар Employee Investment Trust буюу ИАЙТи нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд ажиллагсад болон менежмент банкныхаа бодлогод нэгдмэл байр суурьнаас оролцох үүднээс банкны нийт ажиллагсдын хувьцааг татан төвлөрүүлж, Монголын анхдагч институционал хөрөнгө оруулагчийн үндэс суурийг тавьсан түүхтэй.

ИАЙТи анх 2005 онд үүсгэн байгуулагдах үедээ нийт 1.2 сая төгрөгийн өмч бүхий дүрмийн сантай, 10 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2014 оны жилийн эцсийн байдлаар 330 орчим хувьцаа эзэмшигчтэй, 34 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болж өргөжсөн байна.



1999 онд компанийн үндэс суурь тавигдсан бөгөөд Монголчууд бүтээн байгуулсан баялгийнхаа эзэн байх, институционал хөрөнгө оруулагч бий болгох зорилгыг дэвшүүлж, хэрэгжүүлж ирсэн.

Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага Хөгжлийн Алтан Сан ББСБ, түүний залгамжлагч, нийгмийн хариуцлагаар манлайлагч ХасБанк, түүний толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэлд хөрөнгө оруулалт хийх зорилгоор 2005 онд анх албан ёсоор үүсгэн байгуулагдсан.

Банк, банк бус санхүү, даатгал, үнэт цаас, хөдөөгийн санхүүгийн франчайзингийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө, боловсрол, програм хангамжийн салбарт хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаагаа далайцтайгаар өргөжүүлж чадсан. Монголын анхны хувийн тэтгэврийн сангийн үйлчилгээг нэвтрүүлж, амжилттай туршлага хуримтлуулсан бөгөөд Монголын банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулагчдыг оруулах гүүр болон ажиллаж ирсэн.

2013 онд стратегиа шинэчлэн үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж, санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор санхүүгийн салбарын манлай компаниудыг нэгтгэх үндэсний санаачилга гарч, дээр тулгуурлан Ард Санхүүгийн Нэгдэл үүсгэн байгуулагдсан.

Ард Холдингсын Эрхэм Зорилго

Хөрөнгө оруулалтын өгөөжийг хамгийн өндөр түвшинд байлгахын тулд ашиг болон эрсдэлийн хэтийн харьцааг тэнцвэртэй барих бодлогыг чиглэл болгон ажиллана.



Ард Холдингсын Алсын Хараа


Бид Монгол Улсын хамгийн хүчирхэг санхүүгийн нэгдэл компани байхыг зорьж ажиллах бөгөөд хөрөнгө оруулагчдын санхүүгийн өгөөжийг дээдлэх бодлогыг баримтална.

Үйл ажиллагаандаа баримтлах зарчим

- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана.
- Ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоон дагаж, Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох журам зааврыг чандлан мөрдөнө.
- Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэлийн харьцааг зохистой түвшинд барьж ажиллана.
- Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэн ажиллана.
- Нээлттэй, уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрхэмлэнэ.
- Зах зээлд шинийг нэвтрүүлж, тэргүүлэх бодлогыг Ардын хөрөнгө оруулалттай компаниуд мөрдөж ажиллана.
- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг Ардын хөрөнгө оруулалттай компаниуд чандлан мөрдөнө.
- Хамгийн хүчирхэг, мэргэжлийн, цомхон, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж ажиллах бөгөөд шинээр ажилд орох босгыг өндөрт тогтоож, ажлын байранд тавигдах шаардлага, хариуцлага чанд мөрдөгдөнө.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Төлөөлөн Удирдах Зөвлөл



Ж. Оюунгэрэл
(Петровис ХХК)



Ч. Ганхуяг
(Ард Холдингс ХХК)



О. Одбаяр
(Мон-Интернэйшнл ХХК)



Б. Нэмэхбаатар
(Заг ХХК)



Г. Цогбадрах
(Хараат бус)

Хөрөнгө оруулалтын бүтэц



П. Батбаяр
(Хаан Банк)



Н. Цэлмүүн
(МАК ХХК)



Л. Соронзонболд
(ХХБ)



Энтони Хоброу
(ВенчурсУан БиВи)



Б. Болормаа
(Интергрупп Интернейшнл ХХК)

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

(Мянган төгрөг)

Баланс	12/31/2013	12/31/2014	Өөрчлөлт	%
Мөнгөн хөрөнгө	182,868	408,470	225,602	123
Авлага	1,544,896	1,546,292	1,396	0
Урьдчилж төлсөн тооцоо		79,376	79,376	
Үндсэн хөрөнгө	348,488	447,862	99,374	29
Урт хугацаат хөрөнгө оруулалт	31,499,654	32,331,089	831,435	3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	33,575,906	34,813,089	1,237,183	4
Өр төлбөр			0	
Дансны өглөг	4,727,938	985,727	-3,742,211	-79
Татварын өр	7,452	1,290	-6,162	-83
Хойшлогдсон татварын өглөг *	5,646,944	5,212,734	-434,210	-8
Урьдчилж орсон орлого			0	
Урт хугацаат өр төлбөр	136,179	136,179	0	
Өр төлбөрийн нийт дүн	10,518,513	6,335,930	-4,182,583	-40
Эздийн өмч			0	
Энгийн хувьцаа	1,376,218	1,679,533	303,315	22
Нэмж төлөгдсөн капитал	3,246,555	9,298,761	6,052,206	186
Бодит үнэ цэнийн тохируулга			0	
Эздийн өмчийн бусад хэсэг	13,799	13,799	0	0
Хуримтлагдсан ашиг	18,420,820	17,485,066	-935,754	-5
Эздийн өмчийн дүн	23,057,392	28,477,158	5,419,766	24
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	33,575,905	34,813,088	1,237,183	4

* Хойшлогдсон татварын өглөг нь хөрөнгө оруулалтын дахин үнэлгээнээс үүссэн бөгөөд хувьцаа худалдсанаас бодитоор олз гарз үүсэх үед хэрэгжинэ.


(Мянган төгрөг)

Орлого үр дүнгийн тайлан	12/31/2013	12/31/2014
Үйл ажиллагааны орлого	627,600	107,759
Бодит үнэ цэнийн зөрүүний олз *	16,311,900	831,435
Ерөнхий ба удирдлагын зардал	387,641	819,600
Үндсэн бус ажиллагааны орлого	19,238	43,802
Санхүүгийн зардал (цэвэр)	426,583	151,050
Үйл ажиллагааны бус зардал		224,963
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	16,144,514	(212,617)
Орлогын татварын зардал	8,127	40,153
Хойшлогдсон татварын зардал	4,078,000	83,144
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	12,058,387	(335,913)


* Хувьцаа худалдсаны хэрэгжсэн ашиг 5.5 тэрбум төгрөг. Энд нь бодит үнэ цэнээр дахин үнэлэгдсэн болно.

* Ард Холдингсын 2014 оны аудитлагдсан тайланг цахим хуудас (www.ardholdings.com) - наас татан авч үзэх боломжтой.

Нийт хөрөнгө (сая төгрөг)



Нийт орлого (сая төгрөг)





ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ард Санхүүгийн Нэгдэл гэх шинэ нэрэн доор үйл ажиллагаа явуулсан эхний бүтэн жил бидний хувьд ажил ундарсан, амжилтаар дүүрэн, хийх бүтээх ирмүүн сэтгэлээр бялхсан, баг хамт олон бүрэлдсэн сайхан үе болж өнгөрлөө. Манай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагаа нь тогтмол тасралтгүй явагдаж, бид ТУЗ-ийн ажлыг улам сайжруулж, гүйцэтгэх удирдлагын ажлыг чиглүүлэх, хянах функцийг нь улам төгөлдөржүүлж ирлээ. Ажлын бүтээмж, үр дүнг нэмэгдүүлэх үүднээс байнгын хороодын ажлыг идэвхжүүлж, ТУЗ-ийн хэлэлцэх ихэнх асуудлыг хороодоор дамжуулан шийдвэрлэдэг болж хэвшлээ. Олон улсын тэргүүн туршлагын дагуу манай ТУЗ-ийн дэргэд Аудитын, Эрсдэлийн Удирдлагын, Хөрөнгө Оруулалтын, Засаглал, Нэр Дэвшүүлэх зэрэг хороодын үйл ажиллагаа нь жигдэрлээ. Манай багт Энхтүвшингийн Уранбилэг нэгдэж, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ажлыг чадамгай хийж эхэлсэн нь компанийн засаглалын чанарт мэдэгдэхүйц ахиц гаргах боломжийг бүрдүүллээ. 8 дугаар сарын ТУЗ-ийн хурлаас Чулууны Ганхуягийг Гүйцэтгэх захирлаар томилж, Жанчивын Оюунгэрэлийг ТУЗ-ийн даргаар сонгосон билээ. Харин оны сүүлчээр охин компанийн удирдлагад ажилладаг ТУЗ-ийн гишүүдээ чөлөөлж, бүтцийн зарим өөрчлөлтийг хийн хөгжлийн дараачийн шатны бэлтгэл ажлыг үндсэндээ базааж дууслаа.

2014 онд бид Ардын шинэ лого, уриа, бэлгэдэл зэргийг боловсруулан шинэ баг, бүрэлдэхүүнээ зах зээлд танилцуулсан бөгөөд маркетингийн ажлыг эрчимтэй хийж эхэлснээр тодорхой үр дүнд хүрлээ. Манай вэб хуудас ч Уайлддын залуусын хүчээр богино хугацаанд босож, тогтмол ажиллагаатай боллоо.

Ард Даатгал болон Ард Кредит банк бус санхүүгийн компанийг Интергруппээс өөрийн хувьцаа болон бэлэн мөнгөөр худалдан авах ажиллагааг явуулж дуусган үлдэгдэл болох 1 тэрбум төгрөгийн төлбөрийг оны эхний хагаст гүйцэтгэв. Энэ хэлцлээр бид Ард Даатгалын 33, Ард Кредитын 50 хувийг худалдан авсан бол Интергрупп манай компанийн хамгийн том хувь нийлүүлэгч болж, ТУЗ-д өөрийн төлөөллийг оруулав. Харин 3 дугаар улиралд бид ВенчурсУантай хэлэлцээр явуулж, тэдний эзэмшлийн 22.31 хувийг мөн хувьцаагаар солилцох тохиролцоонд хүрсэн бөгөөд энэ гүйлгээг он дуусахаас өмнө гүйцэтгэснээр бид Ард Даатгалын 55.31 хувийг эзэмшиж эхэллээ. Харин ВенчурсУан Ард Холдингсын 7.76 хувийг эзэмших болсон бөгөөд 2015 онд тэд энэхүү эзэмшлийн хувиа нэмэгдүүлэх аман тохироо хийгдсэн болно.

Ард Кредит нийт 300 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд 2015 он гарсаар анх удаа ногдол ашиг төлөх шийдвэр гаргасан нь түүхэн амжилт гэж бид дүгнэж байна. Бид энэхүү компанийн бусад 50 хувийг эзэмшигчдэдээ маш таатай нөхцөлтэй худалдан авах саналыг хүргүүлж, 8 хувийг нь нэмж авахаар болсон бөгөөд 2015 оны эхний хагаст багтаан энэ өөрчлөлтийг бүртгүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр Ард Кредит дэх бидний хувь эзэмшил 58 хувьд хүрч, бид Ард Кредитыг Холдингсын санхүүгийн тайлангийн нэгтгэлд оруулах боломж бүрдэж байгаа юм.

Өнгөрсөн онд Компани нь нийт 580 сая төгрөгийн хувьцааг буцаан худалдан авч халаасалсан бөгөөд нийт хувьцааны хоёрдогч арилжааны дүн 1.2 тэрбум төгрөг, ВенчурсУантай хийсэн хувьцааны своп арилжаанд зориулж нийт 2.7 тэрбум төгрөгийн



хувьцааг гаргасан байна. Компани халаасны хувьцаанаасаа нийт 180 саяын хувьцааг худалдаж эргэлтэнд гаргасан байна. Манай том хувьцаа эзэмшигчдийн эгнээнд Николь Борохов, Хулдоржийн Бүрэн-Эрдэнэ нар мөн нэмэгдлээ.

Ард Холдингс өөрийн хөрөнгө оруулалтын багц дахь компаниудын үйл ажиллагааг дэмжиж, энэ онд төлөвлөсөн зарим ажлыг амжилттай гүйцэлдүүлэх үүднээс өөрийн өмчийн хуучин ажлын байраа Ард Даатгалд түрээслэн 20 хувийг нь эзэмшдэг Өнгөт Хэвлэлийн байрыг засаж тохижуулан зарим охин компаниудын хамтаар нүүн орлоо. Ингэснээр бид өдөр тутмын үйл ажиллагаа явуулах тав тухтай орчныг бүрдүүлэн холдинг компанийн ажлыг төвлөрүүлж илүү эрчтэй, үр дүнтэй ажиллах нөхцөлийг бий болгосноос гадна хөрөнгө оруулалттай компаниудын ажлын уялдаа холбоог илүү нягтруулж, ойрхноос удирдлагаар хангах боломжтой боллоо.

Манай шинэ байранд Ард Кредитын захиргаа, Ард Даатгалын салбар, Ард Секюритиз, Ард Актив, Уайлд Дижитал Эйженси, ТэнГэр Системс ажлаа явуулж эхлээд байгаа бөгөөд цаашид манай хөрөнгө оруулалтын сан болон түүний менежментийн компани болох Ард Менежмент байрлаж, бид бололцоогоо харж байгаад бусад компаниудад ажлын байр түрээслэх боломжийг судалж байна.

Монголын Хөрөнгийн Бирж дээр өөрийн хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалж эхлэх ажлын бэлтгэлийг мөн энэ байршлаас хийх нь тохиромжтой гэж бид үзсэн болно. Тухайн байрны байршил болон хэмжээ, хэлбэр нь бидний төлөвлөсөн ажилд бүрэн нийцэхээс гадна бид цаашид үйл ажиллагаагаа

өргөжүүлэх боломжийг олгож байна.

2014 онд манай ТУЗ болон хувь нийлүүлэгчид хаалттай компани болж бүртгүүлэх асуудлыг шийдэж өгсөн билээ. Хэдий тийм боловч энэ ажил тодорхой шалтгааны улмаас сунжирч 2015 оны эхний хагаст биелэх боломжтой болж байна. Бид оны эцсийн улиралд Жинст Увс ХК-ийг худалдан авах шийдвэрийг гарган эрчимтэй хэлэлцээр явуулсны үр дүнд 2015 оны эхний улиралд блок арилжааг Монголын Хөрөнгийн Бирж дээр явуулсны үр дүнд тус компанийн 84.6 хувийг худалдан авч чадлаа. Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах Хорооны удирдлагууд бидний ажлыг ямагт ойлгож, дэмжиж ирсэн бөгөөд 2015 онд Ард Санхүүгийн Нэгдэл болон Жинст Увсын нийлэх үйл явц нь Монгол Улсын хөрөнгө санхүүгийн зах зээлийн хөгжлийн нэгэн түүхэн хуудас болж тэмдэглэгдэн үлдэх нь дамжиггүй юм.

Санхүүгээс бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа манай түүхэн хөрөнгө оруулалттай компаниудыг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нийцүүлэн хаалттай хөрөнгө оруулалтын санд шилжүүлэн тусгай зөвшөөрөлтэй менежментийн компани байгуулж удирдах шийдвэрийг бид гарган ажиллалаа.

Ард Санхүүгийн Нэгдэл 2014 оны хувьд нийт 4.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол манай үнэлгээ 34 тэрбум төгрөгт хүрч, нэгж хувьцааны үнэлгээ 2,024.3 төгрөгт хүрлээ.

Манай компанийн санхүүгийн тайлангийн аудитыг BDO Аудит дахин гүйцэтгэхээр болсон бөгөөд энэ удаад тэд нэгдлийн бүх компанийг аудитлаж, санхүүгийн тайлангийн нэгтгэлд мөн дүгнэлт хийхээр болсон билээ.

ҮНЭЛГЭЭ

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

(сая төгрөг)



Хөрөнгө оруулсан компани	12/31/2013	12/31/2014	Эзэмшил %	Үнэлгээний суурь
Тэнгэр Санхүүгийн Нэгдэл	19,444	11,685	4.26	Сүүлийн арилжааны үнэ
Техник Технологийн Дээд Сургууль	9,825	9,825	50.00	Үл хөдлөх хөрөнгийн үнэ
Ард Даатгал		6,637	55.31	Сүүлийн арилжааны үнэ
Ард Кредит		1,600	50.00	Сүүлийн арилжааны үнэ
Ард Секюритиз	983	983	100.00	Мөнгөн урсгал
Номын Хишиг	1,049	1,382	20.00	Үл хөдлөх хөрөнгийн үнэ
Бусад	199	219		Хөрөнгө оруулалтын өртөг
НИЙТ УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	31,500	32,331		
Богино хугацаат хөрөнгө оруулалт	534	959		Хөрөнгө оруулалтын өртөг
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	32,034	33,290		
Компанийн хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	511	897		
Мөнгөн хөрөнгө	183	408		
Цэвэр авлага/ өглөг	(3,324)	(596)		
Дүн	(2,630)	710		
Нийт үнэлгээ	29,404	34,000		

Эргэлтэнд гаргасан хувьцааны тоо	13,762,180	16,795,333
Нэгж хувьцааны үнэ	2136.5	2024.3

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

2014 онд 4.6 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 109.1 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Нэгж хувьцааны үнэ оны турш тогтвортой байсан бол 12 сард 2024.3 төгрөг болж хаалтын ханш нэг дахин өсөв. Энэ нь компани үйл ажиллагаагаа өргөжүүлж, Ард Даатгал дахь хувь эзэмшлээ нэмэгдүүлэх зорилгоор нэмж хувьцаа гаргасантай холбоотой юм.

Хувьцааны арилжаа





2014 оныг бид амжилт бүтээлээр дүүрэн үдэж өнгөрөөлөө. Бид Ард Санхүүгийн Нэгдэл гэх нэрэн дор цугларсан хэсэг компаниудын хамтрал, хэн нь юу хийж, хаана байх ерөнхий ойлголт төдий болоод өнгөрөгч оныг угтаж байсан бол өнөөдөр, ганцхан жилийн дотор өөрийн онцлог өнгө үзэмжтэй, өвөрмөц үзэл баримтлалтай, нэг чигт тэмүүлсэн бат бэх хамт олон болон бүрэлдлээ. Бидний явах чиг улам бүр тодорхой болж, Ард Холдингсын бэлгэдэл, эрхэм зорилго, үнэт зүйлсийг хувь нийлүүлэгчид, удирдлагын баг, ажиллагсад таашаан хүлээн авч, эднийгээ тойрон нягтарч эхэлж байна. Биднийг Монголын нийгэм таньдаг болж, манай үйлчилгээ олон түмний таашаалд хүрч эхэлж байна. Ардын баг удирдлагын бүтэц, ажлын арга барил, байгууллагын соёлын үрийг тарьж, үндсийг нь тавьлаа. Сайн засаглал, санхүүгийн ил тод байдлын хувьд ч тодорхой ахиц гаргаж ажилласан болно.

Бидэнд, нэг баг, нэг байгууллагын хувьд 2015 онд хийж гүйцэлдүүлэх ажил их байна. Дутуу дулимаг үлдээсэн олон ажил гүйцэтгэлээ хүлээсээр байна. Шинээр шийдлээ хайсан асуудлууд ч дор дороосоо ундрал гарч ирж байна. Монгол Улсын маань эдийн засгийн ерөнхий төлөв байдал хүнд, уруудах хандлага ёроолдоо хүрээгүй байгаа нь бидний цаашдын ажлын төлөвлөгөөнд тусгалаа заавал олж авах ёстой.

Нэгдлийн хувьд 2015 онд тавьж байгаа хамгийн том зорилт бол Монголын Хөрөнгийн Бирж дээр өөрийн хувьцааг бүртгүүлж, хувьцааныхаа хөрвөх чадварыг эрс нэмэгдүүлэх явдал мөн. Бидний хийх бүхий л ажил зөвхөн энэ чиглэлд төвлөрөх ёстой.

Багийн гишүүн бүрийн үүргийг тодорхой болгож, гүйцэтгэлийн хариуцлагыг хүн бүрээр нэхэж ажиллах болно. Багийн тоглолтыг эрхэмлэж ажиллахыг бид бие биенээсээ шаардаж ажиллана.

Бид өмнө хуримтлуулсан туршлага дээрээ суурилан Компанийн стратегийн чиглэлийг тогтоосон бөгөөд санхүүгийн тогтвортой үйл ажиллагаанд хүрэх бодлогыг хэрэгжүүлэхдээ Ард Холдингс өөрөө захиргааны нүсэр бүтэц, хүнд ачаа болж хувирахгүй байхыг зорьж ажиллалаа. IPO хийхтэй холбоотой үнэлгээ тогтмол хийгдэж, энэ ажил нь бидний ажлын ойрын үеийн ерөнхий чиглэлийг тодорхойлох болно. Үүний хажуугаар Компанийн засаглал зөв зүгт чиглэн хөгжиж ирлээ. Бид үйл ажиллагааны хувьд аль болох бага зардлаар хувь нийлүүлэгчдийн өгөөж, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой ажиллаж ирлээ. Ард Холдингсын дунд хугацааны зорилго нь үр дүнтэй стратегийн менежмент, эрсдэлийн менежмент, сангийн удирдлага, хөрөнгө оруулагчийн харилцаа, маркетинг, дотоод хяналттай холбоотой функцийг группын хэмжээнд бий болгоход оршино. Группын дотоод огтолцоо борлуулалт, нөөцөө зөв зохистой хуваарилж, хуваалцах чадавхыг бий болгох шаардлагатай. Бид өөрийн бүтэц, зохион байгуулалтыг аль болох уян хатан байлгахыг зорьж ажиллана.

Нэгдлийн эзэмшилд буй стратегийн бус хөрөнгийг нэгтгэх, төвлөрүүлэх зорилгоор бид хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгийн удирдлагын компанийг үүсгэн байгуулсан. Холдингсын бизнесийн стратегийг тусгаарлан тодорхойлох зорилгоор, санхүүгийн бус хөрөнгө оруулалтуудыг хөрөнгө оруулалтын санд шилжүүлж, тэдгээрийг Ард Капитал Менежмент хэмээх мэргэжлийн компанийн удирдлагад өгч, цаашид шинээр санхүүжилт татах, салбарын шилдэг мэргэжилтнүүдийг хамтран ажиллах боломжоор хангаж өгнө. Энэ жилээс сангийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд бид анхдагчийн хувьд давуу байдлыг бий болгохыг зорьж ажиллана. Энэхүү санг бид Equity Investment Trust буюу Хөрөнгө Оруулалтын Итгэлцлийн Сан гэх түүхэн нэрэн дор авч явах санаатай байгаа.

Ард Санхүүгийн Нэгдэлийн хувьд ойрын ирээдүйд хэрэгжүүлж болох зарим боломжит арга хэмжээний талаар товч бөгөөд тодорхой танилцуулгыг хүлээн авна уу?

Нэгдүгээрт, бид 2007 оноос хойш амжилттай ажиллуулж ирсэн туршилтын хувийн тэтгэврийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн зах зээл дээр анхдагч байдлаа баталгаажуулж ажиллахыг зорьж байна. Шаардлагатай хууль тогтоомж байхгүйгээс үүдэн одоогийн байдлаар тэтгэврийн бүтээгдэхүүн нь Ард Активын хадгаламж, зээлийн тусгай зөвшөөрлийн дагуу урт хугацаат хадгаламжийн хэлбэрээр явж байна. Ажил олгогч, ажилтан хоёр талаасаа тохирсон хувиар тэтгэврийн дансанд цалингийн тодорхой хувийг хадгалуулах гэрээ байгуулдаг болно. Хуримтлагдсан хөрөнгөөр гишүүдэд зээл олгож байна. Энэ тогтолцооны дагуу оролцогч бүх талуудад ашиг өгөөж гарч байгаа. Бидэнд цаашид баримтлах хоёр замын сонголт байна. Эхнийх нь, ижил бүтээгдэхүүн санал болгох амьдралын даатгалын компани эхлүүлэх явдал юм. Хувийн тэтгэврийн тухай хууль хүчин төгөлдөр болмогц бодит тэтгэврийн сангийн үйл ажиллагаа руу хөрвөх алхам хийх болно. Одоогоор бас нэгэн хувилбарыг судалж байгаа нь амьдралын даатгалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг худалдан авах замаар амьдралын даатгалын бүтээгдэхүүн эхлүүлж болох юм.

Хоёрдугаарт, ердийн даатгалын зах зээлийн хөгжил сул байна. Түгээлтийн шинэ техник, технологийг судалж, маркетингийн кампанит ажлыг өрнүүлэн шинэлэг бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх нь эерэг үр дүнд хүргэнэ. Нөөц сангийн хөрөнгө оруулалтын менежментийн чадварыг төгөлдөржүүлэх нь даатгал болон тэтгэврийн сангийн аль алинд тулгамдсан асуудал болоод байна. Үүнийг бид аажмаар, тооцоон дээр тулгуурлан нэвтрүүлэх ёстой.

Гуравдугаарт, франчайзын хоршоодоор дамжуулан хөдөө орон нутгийн бичил санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэх нь онцгой боломжийг бий болгож өгч байна. Одоогийн байдлаар манайтай хамтран ажиллагааны гэрээтэй холбоонд 12 мянган гишүүнтэй 49 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Сургалт, франчайзын багц, банкны удирдлагын програм хангамж, бөөний зээлийг бид одоогоор санал болгож байна. Олон нийтийн цахим мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглан хувьсгалт шинэчлэлийг бид хийх боломжтой байна. Фэйсбүүкийг ашиглан зах зээлд брэндээ таниулж, бүтээгдэхүүн борлуулж, зээлдэгчийн зээлийн түүхийг нийгмийн сүлжээг ашиглан баталгаажуулах, онлайнгаар батлах, зээлийн баримтыг бүрдүүлэхэд оршино.

Дөрөвдүгээрт, Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн талаар баримтлах бидний бодлого хэвээр байгаа. Ард Холдингс ижил төстэй үзэл баримтлалтай хөрөнгө оруулагчидтай хүчээ нэгтгэж Тэнгэрт эзэмшдэг хувь эзэмшлээ нэмэх бодлогыг барих бөгөөд цаашид хоёр нэгдэл синерги үүсгэх нь хувь нийлүүлэгчдийн хувьд асар их үнэ цэнийг авчрах боломж харагдаж байна.

Чулууны Ганхуяг

*Монголчууд бид Хийморьтой,
Хамтдаа байхдаа Хүчтэй*

Товч намтар

Монголын Хөрөнгийн Биржээс 1991 онд хөдөлмөрийн гараагаа эхэлсэн тэрбээр 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг дүүргэж, Монголбанкинд хянан шалгагчаар оржээ. 1998 онд НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежерээр шалгаран ажиллаж байгаад 1999 онд Монголын анхны банк бус санхүүгийн байгууллага болох Хөгжлийн Алтан Сан (ХАС)-г байгуулан Гүйцэтгэх захирлаар нь томилогдсон юм.

ХАС нь бичил зээлийн үйл ажиллагааг амжилттай явуулсаар 2001 онд Говийн Эхлэл ББСБ-тай нэгдэж, өнөөгийн ХасБанк байгуулагдсан юм. Ганхуяг нь ХасБанкийг байгуулагдсан цагаас нь хойш 2009 оныг хүртэл Гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд 2009-2010 онд ХасБанкны толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн Гүйцэтгэх захирал байжээ. Мөн тэрбээр Гүйцэтгэх Захирлуудын клуб (CEO club)-ын анхны ерөнхийлөгч, Монголын Ипотекийн Корпорацийн анхны ТУЗ-ийн даргаар тус тус ажиллаж байсан байна.

2010-2012 онд Монгол Улсын Сангийн Дэд сайдын албанд томилогдон ажиллажээ. Тэрээр Унгар улсын өргөмжит консул, Монголын Эдийн Засгийн Форумын санаачлагч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч, Олон Улсын Бичил Санхүүгийн Төвийн УЗ-ийн гишүүн, Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгч гэх мэт албан тушаал хашиж байснаас гадна Монгол Улсад анхлан хадгаламж зээлийн хоршооны хөдөлгөөнийг 1990-ээд оны сүүлээр эхлүүлж, СИДАН ХЗХ-ны Удирдах Зөвлөлийн даргаар ажиллаж байжээ. 2009 онд Дэлхийн Эдийн Засгийн Форумаас түүнийг Дэлхийн Залуу Манлайлагчаар өргөмжилсөн байна. 2014 оны 8 дугаар сараас Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

5.

КОМПАНИУДЫН
ТАЙЛАН





АРД ДААТГАЛ ХХК



Дагвабалжирын
Чулуунцэцэг


2014 онд Ард Даатгал нь нийт 10.1 тэрбум төгрөгийн даатгалын борлуулалт хийж, цэвэр хураамжийн орлого 8.2 тэрбум төгрөг байсан ба нөхөн төлбөрт 3 орчим тэрбум төгрөгийг олголоо. Оны эцсээр компани 545 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Бид хамтдаа Ард Санхүүгийн Нэгдэл хэмээх хүчирхэг санхүүгийн үйлчилгээний холдинг компанийг бий болгон, харилцагч, түншүүддээ улам бүр ойртон ажиллахыг зорьж байна.

2014 оны эцсээр Ард Санхүүгийн Нэгдэл манай компанийн 55 хувийг эзэмших болж, хамгийн том нөлөө бүхий хувьцаа эзэмшигч боллоо. Өнгөрсөн хугацаанд Ард Даатгал нь салбартаа цорын ганц гадаадын хөрөнгө оруулалттай даатгалын компани байсан бөгөөд хамтран ажилласан ВенчурсУан БиВи-ээс ихээхэн зүйлийг суралцаж, Монгол Улсын санхүүгийн салбарт 2002 оноос хойш хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ажилласан хөрөнгө оруулагч маань хөгжлийн шинэ шатанд гарч, холдинг компанийн түвшинд хамтран ажиллах болсонд баяртай байна. Хэдийгээр тэд шууд хувьцаа эзэмшихээ больсон ч тус байгууллагын төлөөлөл ТУЗ-д үргэлжлүүлэн ажиллахаар болсон бөгөөд бид компанийн засаглалыг сайжруулах, ил тод байдлыг дэмжих үүднээс ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон ажиллуулж байна.


Компанийн удирдлагын багийг бэхжүүлэх үүднээс Санхүү эрхэлсэн захирлаар Ард Холдингсын нягтлан бодогч Т.Батцэнгэл томилогдон, оны сүүлээр шинэ албандаа очлоо. Мөн компанийн дотоод аудитын бүтцийг шинээр бий болгож, дотоод аудиторыг ТУЗ-ийн Аудитын Хорооноос томилон ажиллуулж эхлэв. 2014 онд Ард Даатгал үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойг харилцагч, хамтран ажиллагсдынхаа хүрээнд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ.

Санхүүгийн үзүүлэлт


Нийт хөрөнгө (сая төгрөг)




Эздийн өмч (сая төгрөг)



Хураамжийн орлого (сая төгрөг)



Ашигт ажиллагаа (сая төгрөг)



АРД КРЕДИТ ББСБ ХХК




Чулууны
Ганзориг

2014 он бидний хувьд шинэ хөрөнгө оруулалт хийгдсэнээс хойш шинэ бүтэц бүрэлдэхүүнээрээ бүтэн ажилласан анхны жил гэдгээрээ онцлогтой жил болон өнгөрлөө. Компанийн удирдлагын баг 2014 онд компанийн засаглал болон дотоод үйл ажиллагааны үндэс суурийг зөв тавьж, төлөвшүүлэх тал дээр төвлөрөн ажиллахын зэрэгцээ компанийн өсөлт, ашигт ажиллагааг өндөр түвшинд барихыг зорилоо.

2014 онд Монгол Улсын эдийн засгийн орчин сайнгүй байсан хэдий ч компанийн хамт олны хүчин чармайлтын үр дүнд бидний нийт хөрөнгийн хэмжээ 86 хувь өсөж 3.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 300 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. 2014 онд бид Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл авч, анхны хаалттай өрийн бичгээ гарган дотоодын хөрөнгө оруулагчдад амжилттай борлуулсан, мөн Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг авч дотоодоос санхүүжилт татсан амжилт бүтээл дүүрэн жил боллоо. Ард Кредит нь Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангаас бичил бизнес эрхлэгчдийг дэмжих зориулалттай бөөний зээлийг хүлээн авч, Хөдөөгийн Хадгаламж Зээлийн Хоршоодод бөөний зээл олгож эхэлсэн явдал нь компанийн түүхэнд мөн тодоор тэмдэглэгдэх үйл явдал боллоо.

2015 оны хувьд бид гадны бичил санхүүгийн сангуудаас санхүүжилт татах, бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулан дэвшилтэт технологи дээр суурилсан шинэ арга барилыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилт тавьж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд



АРД АКТИВ ХЗХ



Мөнх-Очирын
Сэргэлэн


Ард Актив ХЗХ нь Монголын Тэтгэврийн Нэрийн Данс буюу МТНД ХХК-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах зорилготойгоор 2014 онд Траско ХЗХ-нд Ард Санхүүгийн Нэгдэл болон бидний хэдэн нөхөд элсэн орсноор үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм.

2014 онд бид Ард Санхүүгийн Нэгдэлийн гишүүн компаниудтай гэрээ байгуулан, ажилчдын тэтгэврийн урт хугацаат хадгаламжийг нээн ажиллуулсан бөгөөд тайлант хугацаанд нийт гишүүдийн тоог 332-т хүргэлээ. 2014 онд манай нийт актив 524 хувиар өсжээ.


Манай хамт олон Монголын хамгийн анхны хувийн тэтгэврийн сангийн залгамж халааг аван урт хугацаат хадгаламжийн үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байгаагийн хувьд энэ салбарыг хөгжүүлэх, түүний хууль эрх зүйн орчинг таатай болгоход хувь нэмрээ оруулан ажиллана гэдэгт итгэлтэй байна. Бид олон улсын тэтгэврийн сангийн тогтолцоог өөрийн орны онцлогтой уялдуулан нутагшуулж, бодит тооцооллыг хийж, сангийнхаа гишүүддээ өгөөжийг зөв хүртээн ажиллахыг зорьж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд


Зээлийн мэдээлэл (сая төгрөг)



Хөрөнгийн мэдээлэл (сая төгрөг)



Гишүүдийн тоо



АРД СЕКЮРИТИЗ ҮЦК



Арьясүрэнгийн
Батболд

Монгол Улсын эдийн засгийн өсөлт удааширсан тэр дундаа үнэт цаасны зах зээл жил ирэх тусам хумигдаж байгаа үед Ард Секюритиз ҮЦК ХХК үйл ажиллагаагаа амжилттай явуулж ирсэн байна.

2014 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 60.3 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан ба үүнээс Засгийн газрын үнэт цаасны арилжаа 59.8 хувийг, хувьцааны арилжаа 24.2 хувийг эзэллээ. Монгол Улсын Засгийн Газраас төсвийн алдагдлыг нөхөх, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохицуулах зорилгоор гаргасан Засгийн Газрын үнэт цаасыг эс тооцвол оны турш хувьцааны арилжаа өмнөх онтой харьцуулахад 3 дахин бага үнийн дүнтэй байлаа.


Компанийн зүгээс энэхүү нөхцөл байдалтай уялдан зардлаа хэмнэх, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үйл ажиллагааны үндсэн чиглэл болгох, Ард Санхүүгийн Нэгдэлийн доорх компаниуд, группын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр нэлээдгүй ажил гүйцэтгэн 2014 оныг амжилттай үдлээ.

2014 онд нийт 308.0 сая төгрөгийн орлоготой, 281.5 сая төгрөгийн зардалтай, нийт 26.5 сая төгрөгийн ашигтай ажилласан. Тайлант хугацааны татварын дараах цэвэр ашиг 23.1 сая төгрөг байна. Тайлант оны эхний хагаст үйл ажиллагаагаа ихэвчлэн Ард Санхүүгийн Нэгдэл болон түүний хамаарал бүхий компаниудаар хязгаарлаж байсан бол гадагш чиглэсэн маркетингийн ажил болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн ажлыг оны хоёрдугаар хагасаас эхлэн идэвхжүүлж ажилласан болно.


Хэдийгээр эдийн засгийн хямрал үргэлжилж, өсөлт удааширсан, гадаадын хөрөнгө оруулалт өмнөх дөрвөн жилийн оргил үеэс даруй 5 дахин унасан хүндхэн нөхцөл байдалд ажилласан ч компани анх удаа өнгөрсөн 4 жилийн хугацаанд ашигтай ажилласан үзүүлэлттэй байлаа.

Санхүүгийн үзүүлэлтүүд


Харилцагчийн тоо




Орлого, ашиг (сая төгрөг)



Орлого, ашиг (сая төгрөг)



Хөрөнгө (сая төгрөг)



ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ



Барамсайн
Ганбат

30 жилийн түүхэн замналтай боловсролын байгууллагын хувьд 2014 он амжилт бүтээлийн жил болж өнгөрлөө. Тус сургууль хичээлийн жилээ шинээр байгуулагдсан Монгол Коосэн Технологийн ахлах сургуулийн үйл ажиллагааг эхлүүлж, ойн арга хэмжээний хүрээнд гадаад дотоодын өндөр зочид гийчдийн айлчлал ар араасаа залгуулж, нэр хүндтэй Форбес сэтгүүлээс Монгол Улсын шилдэг 10 сургуулийн нэг, технологийн чиглэлд 2 дугаарт эрэмбэлсэн амжилтын жил болов.


Сургуулийн оюуны өмчийн талаар баримтлах бодлогыг тодорхойлох, технологи дамжуулах, түүний үр дүнд бий болсон хөрөнгө санхүүгийн эх үүсвэрээр сургалт, судалгааны ажлыг дэмжих, гадаадын технологийг нутагшуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гадаад дотоодын ижил төстэй байгууллагуудын хооронд технологийн туршлага солилцох, тэдэнд зуучлах үүрэг бүхий Технологи нэвтрүүлэх төвийн үйл ажиллагааг бид эхлүүлээ.

Мэргэжилтэй ажилтан бэлтгэсэн 30 жилийн хөдөлмөрийн үр шим, залгамж халааг амжилттай үргэлжлүүлэн Ур чадвар уралдааны дэлхийн аваргад хүчээ сорихоор улс орон даяар шалгаруулсан 9 мэргэжлийн тамирчдаас Барилгын мужаан, Хоол үйлдвэрлэл, Гагнуур мэргэжлээр зөвхөн манай сургуулиас 3 суралцагч Бразил улсад болох Дэлхийн тэмцээнд явах эрх авч энэ зуны шийдвэрлэх тэмцээний бэлтгэл ажилдаа орлоо.


Бидний цаашдын их ажлын нэгээхэн хэсгийг дурдахад ийм бахархалт үйл явдлаар дүүрэн байгаад сургууль хамт олон сэтгэл өндөр байж хийх бүтээх эрмэлзэл дүүрэн байгааг мэдэгдэхэд таатай байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд


Өр төлбөр, эздийн өмч (сая төгрөг)




Эздийн өмч (сая төгрөг)



Нийт орлого (сая төгрөг)



Ашиг (сая төгрөг)



ТЭНГЭР САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХХК

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьд үйл ажиллагааны хувьд томоохон өөрчлөлтүүд гарсан жил байлаа. 2014 оны 7 дугаар сараас ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн зүгээс тус компанийн гүйцэтгэл, цаашдын үйл ажиллагаанд ихээхэн шүүмжлэлтэй хандаж, компанийн үйл ажиллагааг татан буулгах, гол хөрөнгө оруулалтдаа анхаарал хандуулж ажиллах шийдвэр гаргаснаар менежментийг ХасБанк руу шилжүүлэн, бүтцийн өөрчлөлт хийлээ. Улмаар 2014 оны 7 дугаар сард ХасБанкны гүйцэтгэх удирдлагад мөн өөрчлөлт оруулсан байна.

Оны эцэст компанийн хувьцаа эзэмшигчид болох МСиЭс Холдинг болон Мерси Корпс байгууллагууд эзэмшиж буй хувьцаагаа Канадын Үндэсний Банкинд худалдах тухай санал ирүүлсэн боловч хувьцаа худалдах, худалдан авах ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшилж, 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас хувьцаа эзэмшигчид энэхүү үйл явцыг үргэлжлүүлэх талаар санамж бичиг байгуулахаар тогтсон билээ.

Ард Санхүүгийн Нэгдэл ХХК нь хувьцаа эзэмшигчийн хувьд дээрх арилжаанд оролцож, хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэн худалдахаар санал болгож буй хувьцаанаас худалдан авахаар саналаа явуулаад байна.

Группын хөрөнгө 2.2 их наяд төгрөгт хүрч 2014 онд 15 хувийн өсөлттэй байлаа. Энэхүү өсөлтөд банкны харилцах хадгаламж 21 хувь өссөн нь ихээхэн нөлөөлсөн ба гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас шинээр 160 сая долларын зээлийн эх үүсвэр татсан нь мөн чухал нөлөө үзүүлжээ. Нийт зээлийн багц 1.4 их наяд төгрөгт хүрч, 28 хувийн өсөлттэй гарсан байна.

Эрсдэлтэй зээлийн багц 3.7 хувь байсан нь өнгөрсөн үеийнхтэй харьцуулбал 1.4 хувиар өндөр үзүүлэлт байлаа. Компани 2014 онд 27.6 тэрбум төгрөгийн ашиг төлөвлөж байсан ч оны эцсийн байдлаар 14.7 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өөрийн хөрөнгийн өгөөж 9.5 хувьтай байсан байна.

Группын тэргүүлэгч компани болох ХасБанк өнгөрсөн жил банкны үндсэн системээ шинэчлэн Flex Cube 12.0 гэсэн шинэ хувилбар руу амжилттай шилжсэн байна. Банкны нийт хөрөнгө өнгөрсөн онтой харьцуулбал 15 хувь өсжээ. 2014 оны эцсээр банк нийт 1,732 ажилтантай байсан.

ХасЛизинг ХХК-ийн цэвэр ашиг 1.8 тэрбум төгрөг байсан ба өөрийн хөрөнгийн өгөөж 18.7 хувьтай гарав. Оны эцсээр компани 45 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, үүнээс 27.6 тэрбум төгрөгийн зээлийн багцтай байлаа. Эрсдэлтэй зээлийн багц 4.3 хувь эзэлж байна.

Тэнгэр Даатгал ХХК нь 2014 онд ний 8.1 тэрбум төгрөгийн даатгалын орлого олсон ба жилийн эцсээр 755 сая төгрөгийн ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөж 18.6 хувь байлаа.

БНХАУ-ын Шинжаан мужид үйл ажиллагаа явуулж байгаа ТианРонг Кредит санхүүгийн компани нь 2014 оны эцсээр 33.8 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, өмнөх оноос 20 хувийн өсөлтийг үзүүллээ. Зээлийн багц 27.6 тэрбум төгрөгт хүрч, эрсдэлтэй зээлийн багц 0.8 хувьтай байжээ. 2014 онд компани татварын дараа 2.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба өөрийн хөрөнгийн өгөөж өнгөрсөн онд 3.8 хувь байсан бол 2014 онд 6.9 хувьд хүрсэн амжилттай ажиллав.



ТЭНГЭР СИСТЕМС ХХК



Чулууны
Ганхуяг


Манай компани нь өнгөрсөн онд стратегийн онцгой ач холбогдолтой томоохон өөрчлөлт, шийдвэрүүдийг гарган ажиллалаа. Анхны бүтээгдэхүүн болох GeniusBanker програм хангамжийг хэрэглэдэг байгууллагуудтайгаа гэрээгээ шинэчлэн байгуулж, харилцагчдынхаа тоог нэмэгдүүлж одоогоор 50 гаруй харилцагч байгууллагатай болсон байна. Үүнд 43 хадгаламж зээлийн хоршоо, 3 банк бус санхүүгийн байгууллага, 5 бусад аж ахуйн нэгж манай програмыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2014 онд Тэнгэр Системс нь Энэбишийн Сундуйтай (Африкийн Намиби улсад банкны програм хангамжийн зөвлөхөөр ажиллаж буй) хамтран TERBiUM нэртэй банкны цогц үндсэн системийг бий болгох хамтын ажиллагааг эхлүүллээ. Энэхүү системийг хөгжүүлэх баг бүрдсэн бөгөөд бүтээгдэхүүнээ дотоодын зах зээл болон Африк тив дэх бичил санхүүгийн байгууллагуудад борлуулахаар төлөвлөн ажиллаж байна.


2015 онд бид TERBiUM бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлж, бусад програм хангамж болон банкны тоног төхөөрөмжийг (интернет банк, пос төхөөрөмж) зах зээлд нийлүүлэхээр ажиллаж байна. Бид ойрын хугацаанд санхүүгийн хувьд биеэ даасан, цаашид өсөж торних боломжтой бүтэцтэй томоохон компани болохоор хичээн ажиллаж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд

Эздийн өмч, Орлого (сая төгрөг)



Нийт хөрөнгө, биет бус хөрөнгө (сая төгрөг)



НОМЫН ХИШИГ ХХК




Өнөрбаянгийн
Аишуу

Номын хишиг ХХК нь 2008 оноос эхлэн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа явуулж байна. 2014 оны 2 дугаар сард Ард Санхүүгийн Нэгдэл ХХК Номын хишиг компанийн 20 хувийн хувьцаа эзэмшигчээр орж ирсэн билээ.


Нийт 2304 м² талбайтай барилгын 2170 м² талбайг 5 түрээслэгчид түрээсэлж байгаа бөгөөд ойрын хугацаанд барилгын суурийн давхар болон дээврийн хэсгийг өргөтгөж ашиглах, гадна тохижилт, фасадыг шинэчлэх зэрэг ажлуудын төлөвлөгөөг боловсруулж байна. Мөн цаашид түрээсийн тогтвортой орлогыг бүрдүүлэх, үр ашигтай зарцуулах бодлого боловсруулахаас гадна, хотын төвийн АА зэрэглэлийн байршлаа ашиглан хөрөнгө оруулалт босгох зорилт тавин ажиллаж байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд


Эздийн өмч (сая төгрөг)



Нийт орлого (сая төгрөг)



Ашиг (сая төгрөг)



УАЙЛД ДИЖИТАЛ ЭЙЖЭНСИ



Энхболдын
Тэнүүн


Бидний хувьд 2014 он Монголдоо урдаа барих чиглэл бүртээ таваас дээш жил ажилласан туршлагатай залуусыг бүрдүүлж, бүх төрлийн дизайны шийдэл, вэбсайт, сошиал медиа маркетингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан амжилт бүтээл арвин, сурч мэдсэн зүйл ихтэй гарааны жил байлаа. 2015 онд брэндингийн чиглэлээр мэргэшсэн, туршлагатай компани болж төрөлжин ажиллах зорилго тавин ажиллаж эхлээд байна.

Манай анхны хамтрагчид болох Ард Холдингс, Америкийн Худалдааны Танхим буюу АмЧэм, APCAC, Скүэр Грил Паб, Интергруп Интернэйшнл зэрэг томоохон байгууллагуудын цахим орчин дахь өнгө төрхийг цогцоор шийдсэн бөгөөд одоо эдгээрийн томоохон ребрэндийгийн ажлыг гүйцэтгэж байна. Бид 2015 онд хамтрагчиддаа илүү чанартай, ойр үйлчилгээг хүргэх арга барилыг нэвтрүүлэхээр зорьж байна.


Уайлд шинээр бий болж буй чадварлаг компаниудтай хамтын ажиллагааг өрнүүлэх, шинээр мобайл болон технологийн шийдэл, бүтээгдэхүүнийг гаргахаар шамдан ажиллаж эхлээд байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд

Орлого, Өмч (сая төгрөг)



Хөрөнгө



ARD САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Хөрөнгө оруулалттай компаниуд:



Ердийн даатгал



Техник Технологийн
Дээд сургууль

Технологийн дээд
боловсрол, Коосон



Брокер, дилер, андеррайтер,
хөрөнгө оруулалтын зөвлөх



Вэб сайт, маркетинг,
бренддинг



Санхүүгийн цогц
үйлчилгээ



Үл хөдлөх хөрөнгө



Урт хугацаат хадгаламж



Санхүүгийн программ
хангамж



Бичил санхүү

Хүчтэй. Хамтдаа.



www.ardholdings.com

Хөрөнгө Оруулагч Үндэстэн

Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд, Амарын гудамж-2,
Номын Хишиг ХХК-ийн 2 давхарт

☎ 7602 1111

✉ info@ardholdings.com

🌐 www.ardholdings.com

by **WILD**